

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ШҮҮГЧ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

Товч удирдамж: Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв, бүрэн дүүрэн бичнэ. Компьютерын программ ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралтыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ. Мөн, нэр дэвших тухай хүсэлтийг Word-ын файлаар цахим шуудан /сонгон шалгаруулах тухай зард заасан хаяг/-аар тус Байнгын хороонд явуулна.

НЭГ. ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

1.1	Эцэг/эхийн нэр: Жамсран Ургийн овог: Булгадар Нэр: Бат-Амгалан Хүйс: эр Төрсөн он: 1984 [REDACTED] Төрсөн газар: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, [REDACTED]
1.2	Иргэний харьяалал Монгол Улсын иргэн мөн үү /тийм, эсхүл үгүй гэж бичих/.Тийм.....
1.3	Насны дээд хязгаар Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн үү /тийм, эсхүл үгүй гэж бичих/.Үгүй.....
1.4	Шүүгчийн албан тушаал Шүүгчээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, аль шүүхэд ямар хугацаанд шүүгчээр ажиллаж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.Үгүй.....
1.5	Улс төрийн болон намын удирдах албан тушаал Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаа юу, эсхүл эрхэлж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.

	<p>...Монгол улсын иргэн Жамсран овогтой Бат-Амгалан /ЧЛ84110417/ миний бие анх 2011 онд Ардчилсан намд элсч байсан бөгөөд төрийн албанд орсноор түр түдгэлзэж байгаад 2017 оноос Баянзүрх дүүргийн ардчилсан намын гишүүнээр элсч дүүргийн намын хорооны гишүүн бөгөөд аливаа намын удирдах албан тушаал болон төлөөллийн төв байгууллага болох Үндэсний бодлогын хорооны гишүүн байгаагүй болно.</p> <p>Иймд Улс төрийн намын тухай хууль болон Шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.3-д “Ерөнхий зөвлөлийн улс төрийн албан тушаал болон <u>улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй</u>, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй Монгол Улсын иргэн байна” гэсний дагуу сүүлийн таван жил Ардчилсан намын бүх шатны байгууллагад удирдах албан тушаал хашиж байгаагүй болохыг батламжилж байна. Ардчилсан намын тодорхойлолтыг хавсаргав.</p>
1.6	<p>Эрүүгийн хариуцлага Эрүүгийн хариуцлага хүлээж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>..... Үгүй, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй бөгөөд одоо хүлээгээгүй тодорхойлолтыг хавсаргав.</p>
1.7	<p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>..... Үгүй.....</p>
1.8	<p>Монгол Улсын Их Хурлаас Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилохоос татгалзаж байсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшсэн боловч Монгол Улсын Их Хурлаас томилохоос татгалзаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих/.</p> <p>..... Үгүй.....</p>

ХОЁР.ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1	<p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний хувьд хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /тайлбарыг 500-1000 үгэнд багтаана/</p> <p>Хуульч, өмгөөлөгч Ж.Бат-Амгалан миний бие Монгол Улсын Үндсэн хуулийн байгууллага болох төрийн засаглалын нэг мөчир шүүх болон шүүхийн захиргааны байгууллага Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд идэвх санаачилгатайгаар ажиллаж чадна гэдэгтээ итгэл төгс нэр дэвшиж байгаа бөгөөд Шүүхийн Ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр сонгогдон ажиллавал Үндсэн хууль болон Шүүхийн тухай хууль, Шүүхийн хөгжлийн бодлоготой нийцүүлэн холбогдох хуульд заасан чиг үүргийн</p>
------------	--

хүрээнд шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр, гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангахтай холбогдсон үүргийг биелүүлэн хамтын шийдвэр гаргах зарчмыг барьж, багаар ажиллах болно.

Өмнө миний бие 2013-2016 оны хоорон Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албанд ажиллаж Шүүхийн багц хуулийг хэрэгжүүлэх, шүүхийн шинэтгэлийн ажилд гар бие оролцож байсан бөгөөд шүүхийг иргэдэд нээлттэй ил тод, үйлчилгээний байгууллага болгох чиглэлээр идэвхтэй ажиллаж байсан туршлагатай болно. Одоо өөрөө өмгөөлөгч, үйлчлүүлэгчийн үүднээс хуримтлуулсан туршлагаа шүүхийн захиргааны байгууллагын зүгээс ямар ямар ажил хийвэл илүү оновчтой болох чиглэлээр санаачлан хийх тодорхой ажлууд байгаа нь миний давуу тал болно. Шүүх, шүүгчийн хараат бус байдал, эрх ашгийг нь хамгаалах, төсөв санхүү, ажлын байрны стандарт, хүний нөөц, шүүгчийн ачаалал, хэргийн хөдөлгөөн, цахимжилт зэрэг олон асуудалд хуулийн болон бодлогын хувьд энэхүү сонгон шалгаруулалтад оролцож шүүхийн цаашдын хөгжилд хувь нэмрээ оруулж чадна гэдэгтээ итгэлтэй байна.

Миний бие сүүлийн 14 жил эрх зүйч, шүүхийн захиргаа болон иргэний эрх зүйн чиглэлээр мэргэшин дагнан ажиллаж, өмгөөлөгчөөр 9 жил, ялангуяа иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд идэвхтэй оролцож ирлээ.

Энэхүү иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн оролцогчийн хувиар оролцох явцдаа хангалттай туршлага хуримтлуулж, иргэн шүүх болон хэрхэн иргэдэд төвөг чирэгдэлгүй, хүнд сурталгүйгээр процессын хувьд бодлогын болон хуулийн шийдэл гаргаж ажиллаж чадна гэдэгтээ итгэлтэй байна.

Би 2013-2016 оны хооронд Шүүхийн Ерөнхий зөвлөлд ажиллах явцдаа Шүүхийн тухай хуулийн багц хуулиудын багц хуулийн хэрэгжилт, Шүүхийн арван шинэчлэлийн ихэнх бөгөөд тухайлбал Шүүхийн тухай хуулийн хүрээнд хэрэгжих 30 аад дүрэм, журмыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн хуралдаанаар батлуулж, Нээлттэй шүүх үйл ажиллагааг эхлүүлж шүүхийн байрны стандартыг батлуулан улмаар хэргийн хөдөлгөөний программыг буюу иргэн 2014, захиргааны хэргийн хөдөлгөөний программыг ашиглалтад оруулж, эрүүгийн нэгдсэн сүлжээний эхлэлийг тавьсан юм.

Мөн шүүхийн захиргааны удирдлагын газрын түр орлон гүйцэтгэгч байхдаа шүүхийн төрөлжсөн архивын эхлэлийг тавьж эрх зүйн орчинг бүрдүүлэн одоо үйл ажиллагаа нь нэгэнт жигдрэн ажллаж байна.

Эвлэрүүлэн зуучлагчийн эрх зүйн байдлын хуулийн дагуу эвлэрүүлэн зуучлагчийн ажлыг зүгшрүүлэх ажлыг суурийг тавихад хувь нэмрээ оруулсан.

Мөн иргэдийн төлөөлөгчийн саналыг шүүгч шийдвэрийн үндэслэлдээ ишлэдэг хууль нь Үндсэн хуулийн Цэц-д унасны дагуу Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай хуулинд нийцүүлж жил бүр нэрсийн жагсаалт гарган, чөлөө, урамшуулал зэргийг зохицуулах үндсийг гардан гүйцэтгэж, тухай бүр Шүүхийн Ерөнхий зөвлөлөөр батлуулж байсан.

Мөн шүүх хуралдааны танхим болгоныг цахимжуулан камер бичлэг хийж архивлан тухайн шүүхийн үүдэнд дэлгэцээр иргэдэд нээлттэй үзүүлдэг болсон ажлыг гүйцэтгэсэн болно.

Бүх аймаг, дүүргүүдийн шүүхийг төслийн хүрээнд интернетийн шилэн кабельтай холбож хэргийн хөдөлгөөний программууд болон цахимаар шүүх хуралдаанд явуулах боломж нөхцлийг бүрдүүлсэн.

Германы хамтын ажиллагааны байгууллагын тусламжтайгаар шүүхийн шийдвэрүүдийг файл хэлбэрт оруулж шүүхийн нэгдсэн цахим сан буюу SHUUN.MN веб сайтыг хэвийн ажиллагаанд өөрийн биеэр хариуцан ажиллагаанд оруулав.

Мөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны дотоод и-оффисийг шинээр нэвтрүүлж иргэдээс ирсэн гомдол хүсэлт болон дотоод ажлын албаны бичиг хэргийн эргэлтийг хуулийн дагуу хугацаандаа шийдвэрлэх үндсийг бүрдүүлсэн.

Шүүхийн Ерөнхий зөвлөл болон шүүхийн брэнд бүүк болон шүүгчийн үнэмлэхний загварыг батлуулан хэрэгжүүлж шүүхийн спортын наадмыг дахин сэргээн зохион байгуулж байсан зэрэг нь би өөрөө шүүхийн хамт олон дунд нэгээхэн эд эс нь байсны жишээ билээ.

Дараа нь шүүхээс гарч өөрийн “Өмгөөллийн Скай Лекс” ХХН ийг байгуулж шүүхэд гаднаас нь үйлчлүүлэгчийн дүрээр үйлчлүүлж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож 9 жил болохдоо бүх шатны шүүхэд хэргийн оролцогчоор оролцож хангалттай туршлага хуримтлуулсан гэж өөртөө итгэсний үндсэн дээрээс хуулийн болон бодлогын хувьд энэхүү сонгон шалгаруулалтад оролцож шүүхийн цаашдын хөгжилд хувь нэмрээ оруулж чадна гэдэгтээ итгэлтэй байна.

Нэн түрүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг дурьдвал:

- Шүүхийн тухай хуулийн хэрэгжилтэнд Хууль тогтоомжийн хуулийн дагуу 5 жил тутамд мониторинг хийж, цаашид ямар ямар өөрчлөлт, болон сайжруулалт хийх тухай Улсын Их Хурлын Хууль Зүйн байнгын хороо, Ерөнхийлөгчийн тамгын газартай хамтран ажиллах,

- Шүүх, шүүгчийн ачааллын судалгааг хөндлөнгийн байгууллагаар дахин хийлгэж, ажлын байрны зураг авалтын зарчмаар бодит нөхцлийг тодорхойлж, шүүгчийн ачааллыг тэнцвэржүүлэхийн тулд цаашид авах арга хэмжээг тодорхойлох ажлыг хэрэгжүүлэх. Учир нь орон нутгийн шүүхүүд болон Нийслэлд байрлах ялангуяа иргэний хэргийн шүүхийн шүүгчдийн ачааллын зохист харьцаа хэт алдагдсанаас болж шүүхэд итгэх иргэдийн итгэл болон шүүхийн процессийн хурд, чанарт бодитой хүндрэл учирч байна.

- Салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай. Учир нь шүүх нь өөрөө засаглалын нэг салаа мөчир бөгөөд хараат бусаар, бие даан ажиллах үүднээс дэд бүтэц, төсөв, санхүүгийн хувьд улсын төсвөөс санхүүждэг учир Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхийлөгчийн тамгын газар, бусад хууль сахиулах чиг үүргийн байгууллага, Монголын Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоо болон олон улсын байгууллагуудтай олон талаар ажлын бодит нөхцөл боломжийг тайлбарлан таниулж, уялдуулан ажиллах шаардлагатай тул энэхүү ажлыг манлайлан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- Шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын нийгмийн асуудлуудыг шат дараалалтай, үр дүнтэйгээр шийдвэрлэх.

- Шүүхийн байрны ачаалал, стандартыг мөрдүүлж, шүүгч, захиргааны ажилтнуудын ажлын байрны хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэх ажлыг идэвхжүүлэх шаадлагатай.

- Шүүхийн үйлчилгээ болон шүүхийн цахимжилтийг улам эрчимжүүлснээр иргэдэд илүү хүндрэл, чирэгдэлгүйгээр нээлттэй, ил тод үйлчилж, иргэдийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх үр дүнтэй.

- Шүүхийн мэдээ мэдээллийг 7 хоног бүр сэтгүүлчдэд мэдээллэж, аль болох иргэдэд нээлттэй ил тод байснаар аливаа иргэдийн хардлага, сэрдлэг, хаалттай байдал багасдаг. 2014-2016 оны хооронд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 7 хоног бүр мэдээлэл хийж онцлох цаг үеийн мэдээлэл болон хэргийн хөдөлгөөний мэдээ, улирал бүр тайлан болон хэргийн хөдөлгөөний мэдээллүүдийг хэвлэлээр хүргэж байсан нь иргэдийн шүүхэд итгэх итгэлийн индексийн судалгаагаар өсч үр дүнтэй ажил байв. Одоо энэ ажлыг сэргээх шаардлагатай. Хуучин байсан сайн туршлагаа дахин хэрэгжүүлж, одоогийнхоос илүү нээлттэй шүүх болгох зорилготой.

- Улирал бүр шүүгчийн сонгомол, шилдэг шийдвэрүүдийг сонгон шалгаруулж хэвлүүлдэг байсан уламжлалыг сэргээх шаардлагатай. Энэ нь нэг талаасаа шүүгч шийдвэрээ бичихдээ илүү хянуур алдаагүй бичих, нөгөө талаас оюутан залуус, хуульч, өмгөөлөгч, прокурор нарт жишиг гарын авлага болдог сайн талтай энэ ажлыг сэргээх.

- Шүүгчийн гаргасан шийдвэр заавал биелэгддэг байх хууль эрх зүйн орчныг судалж шаардлагатай бол эрх бүхий субъектээр дамжуулан хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг шүүхийн ерөнхий зөвлөлийн бусад гишүүдтэйгээ хамтран хэрэгжүүлэх.

Учир нь Иргэний хэргийн шүүхийн шийдвэр нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дээр очоод гацаад байна гэсэн иргэдийн бухимдал их байна. Тиймээс шүүгч шийдвэр гаргасан бол шийдвэрийнхээ биелэлтэнд араас нь хяналт тавьдаг механизмыг хуульчлах шаардлагатай байна. Гэхдээ эхлээд ажлын эрэмбийн хувьд нийслэлийн иргэний хэргийн анхан шатны шүүх болон хялбар ажиллагааны шүүгчдийн ачааллыг бууруулж байж, шийдвэртээ хяналт тавих нөхцлийг бүрдүүлнэ.

- Шүүгчийн орон тоог Улсын Их Хурлаас баталсан тоонд хүргэх шаардлагатай байна. Ялангуяа нийслэлийн иргэний хэргийн анхан шатны шүүгчийн тоог нэмэхгүй бол нэг шүүгчид хэт олон хэрэг хувирагдаж хэргийн процесс удаашрах, улмаар иргэд шүүхэд итгэх итгэл буурах нэг үзүүлэлт болж байна. Шүүгчийн орон тоог нэмэгдүүлэхийн тулд дараа оны улсын төсөвт цалин ажиллах шүүхийн байр, бусад зардлуудыг тусгуулахын тулд холбогдох суурь судалгаануудыг харьяа болон хөндлөнгийн байгууллагуудаар гүйцэтгүүлэх, төсөв батлах субъектүүдэд сайн ойлгуулах зэрэг цогц ажлыг зохион байгуулах шаардлагатай.

- Юуны түрүүнд талуудыг эвлэрүүлэх ажлыг нэн тэргүүнд тавьдаг байх хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх,

- Тойргийн иргэний хэргийн анхан шатны шүүх болон хялбар ажиллагааны шүүхийн тогтолцоог дахин судалгаа, мониторинг хийж бодлогын оновчтой шийдвэр гаргах процесст идэвхтэй оролцоно.

Шүүгчийн хараат бус байдлыг хангах чиглэлээр:

	<ul style="list-style-type: none"> - Шүүгч сонгон шалгаруулах процесс, томилгоо, чөлөөлөлт нь хараат бус нээлттэй явагдах боломжуудыг нэмэгдүүлэх - Шүүгчийн хараат бус байдлыг хангуулах олон улсын стандартуудыг судалж, нэвтрүүлэх - Шүүгчийн эрх, үүргийг тодорхойлох хууль эрх зүйн орчинг тодорхой болгох, - Шүүхийн үйл ажиллагааг илүү нээлттэй болгож, иргэдийн шүүхийн үйл ажиллагаанд хуулийн дагуу оролцох боломжийг хангах, - Нөлөөллийн мэдүүлэг бөглөх тогтолцоог илүү боловсронгуй болгох, - Иргэдийн төлөөлөгч оролцуулах, сонгох ажлыг илүүл боловсронгуй болгох - Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх, сургалтын төлөвлөгөөг дахин харж, оновчтой төлөвлөгөө боловсруулах, - Орчин үед хиймэл оюун ухааныг /AI/ аливаа байгууллага нэвтрүүлэн ашиглах асуудал хөгжиж байгаатай холбогдуулан шүүхийн байгууллагад түүнийг ашиглах арга, хэлбэр, цар хүрээний талаар гадаад, дотоодын харьцуулсан судалгаа хийж, судалгааны үр дүнд үндэслэн санал боловсруулах, холбогдох эрх бүхий этгээдэд уламжлах, санал солилцох, хамтран ажиллана. <p style="text-align: center;">Иймд би Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний үүргийг шударга, ёс зүйтэй, хууль дээдлэн шүүх эрх мэдлийн байгууллагын хөгжилд хуульч мэргэжлийн хувь нэмэр оруулан ажиллах боломжтой гэдгээ илэрхийлж байна.</p>
--	--

ГУРАВ.МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Д/д	Шалгуур үзүүлэлт
3.1	<p>Эрх зүйч мэргэжлээр ажилласан байдал</p> <p>Хүсэлт гаргагч нь эрх зүйч мэргэжлээр ажилласан байдлын талаар хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар тодорхойлон бичих бөгөөд ажил тус бүрийг эрхэлж байсныг нотлох баримтыг хавсаргана. Ажил тус бүрийг тодорхойлохдоо дараах мэдээллийг заавал бичнэ:</p> <ul style="list-style-type: none"> -албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; -ажлын байрны тодорхойлолтын гол агуулга; -удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/; -тухайн албан тушаал эрхэлж байхдаа хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан таваас доошгүй хүний нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/. <p>2012 оноос эхлэн эрх зүйч мэргэжлээр тасралтгүй ажиллаж байна.</p>

	<p>- 2012-2013 онд “Модерн өргөө” ХХК-д хуулийн зөвлөх, - 2013 онд Ус сувгийн удирдах газарт хуулийн зөвлөх, -Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албанд 2013-2016 -”Өмгөөллийн скай лекс” хуулийн фирмд 2017-2024 -”Түмэнд лоо офис” д одоог хүртэл ажиллаж байна.</p> <p>Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Экспресс тауэр 701, 702 тоот, [REDACTED]</p> <p>1. Т.Мэндсайхан /Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга хийж байсан, шууд харьяалах дарга буюу удирдлага нь байсан. Одоо МУИС-ийн хууль зүйн сургуулийн багш, Түмэнд Лоо Оффиссын хамтрагч, зөвлөх хуульч/ [REDACTED]</p> <p>2. Ц.Амгаланбаатар /Түшээ дээд сургуулийн багш байсан, магистрын багшилж байсан, өмгөөлөгч, ТМ телевизийн Хууль ба Нийгэм нэвтрүүлгийг хамт хөтөлж байсан./ Утас: 98114354</p> <p>3. С.Нэргүй /Шүүхийн ерөнхий зөвлөлд шууд удирдлага дор нь ажиллаж байсан бөгөөд одоо Хан-Уул, Баянгол дүүргийн иргэний хэргийн тойргийн анхан шатны шүүхийн тамгын газрын дарга/ [REDACTED]</p> <p>4. Б.Дагмид-Од /”Улз буянт пропертиз” ХХК-ийн дэд захирал бөгөөд Ж.Бат-Амгалангийн байнгын үйлчлүүлэгч/ [REDACTED]</p> <p>5. Ү.Бат-Эрдэнэ Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны мэргэжилтэн, бөгөөд удирдлага дор нь ажиллаж байсан хүн/ [REDACTED]</p> <p>6. Л.Ариунтулга /Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны мэргэжилтэн, бөгөөд удирдлага дор нь ажиллаж байсан хүн/ [REDACTED]</p>
<p>3.2</p>	<p>Эрх зүйчээс бусад мэргэжлээр эрхэлсэн ажил</p> <p>Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрх зүйчээс бусад мэргэжлээр эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Ингэхдээ ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч /эсхүл удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.</p>
	<p>Анх 2005 онд Оюу дээд сургуулийг менежментийн чиглэлээр төгсч улмаар 2012 он хүртэл эрх зүйч бус мэргэжлээр багш, захиргаа, менежментийн чиглэлээр хувийн хэвшилд ажилласан болно.</p>
<p>3.3</p>	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар</p> <p>Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн, эсхүл хүний эрхийн чиглэлээр ажилладаг бусад холбоо, байгууллагын гишүүн бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар нэрлэн бичиж, гишүүнчлэл тус бүрийг нотлох баримтыг хавсаргана.</p>

	<p>-Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ. Уг байгууллагын гишүүнчлэлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож, дуусгавар болгож байсан бол энэ талаар бичиж, шалтгааныг нь тайлбарлана.</p> <p>-Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байсан албан тушаал, гүйцэтгэсэн чиг үүргийн нэр, огноог хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичнэ.</p>
	<p>- Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульч, - Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн, . - Монголын хуульчдын нийгэмлэгийн гишүүн хуульч,</p>

ДӨРӨВ.ХУУЛЬ ЗҮЙН ӨНДӨР МЭРГЭШИЛ

<p>4.1</p>	<p>Хууль зүйн өндөр мэргэшил Хүсэлт гаргагчийг хууль зүйн өндөр мэргэшилтэй /хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай, мэргэжлийн өндөр ёс зүйтэй/ гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлох бөгөөд үйл ажиллагаа тус бүрийг явуулсныг нотлох баримтыг хавсаргана. Ийм үйл ажиллагаа тус бүрийн талаар дараах мэдээллийг заавал бичнэ:</p> <ul style="list-style-type: none"> -үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; -үйл ажиллагааны гол агуулга; -үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; -үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/; -тухайн үйл ажиллагааны хүрээнд хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан гурваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/; -хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар. <p>10 жил өмгөөлөгчөөр ажиллаж, шүүхийн процесс болон гэрээ болон бусад эрх зүйн баримт бичиг боловсруулах, санал гаргах, гэрээгээр хуулийн төслүүдэд үзэл баримлалын болон Хууль тогтоомжийн хуулийн дагуу судалгаа хийж санал боловсруулах, хуулийн зөвлөгөө сургалт сурталчилгаа хийх зэргээр ажиллаж ирсэн маань хууль зүйн өндөр мэдлэг, ёс зүйтэй талаарх нотлох баримт болно.</p> <p>-2015 онд Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулах ажлын хэсэгт багтаж Эрүүгийн болон зөрчлийн хуулийн нэмэлт өөрчлөлтөд ШЕЗ-ийг төлөөлж санал боловсруулж байсан.</p>
-------------------	---

	<ul style="list-style-type: none"> - Мөн ШЕЗ-ийн ажлын албаны хуулийн ахлах референт хийж байх хугацаандаа олон хуулийн төсөлд ШЕЗ-ийг төлөөлж санал боловсруулж байсан. - ТМ телевизийн хуулийн шууд зөвлөгөө өгдөг Хууль ба Нийгэм нэвтрүүлгийг 2018-2020 оны хооронд хөтөлж Иргэдэд хуулийн зөвлөгөөг шууд эфирээр өгдөг байсан. - 2021 онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын захиалгын дагуу ажлын хэсэг багтаж Төрийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хийж байсан. Одоо батлагдаагүй байгаа. - Т.Мэндсайхан багшийн Гэрээний Эрх зүй номын суурь судалгаа, зарим бүлгийг бэлтгэж байсан. - Мөн мэргэжлийн хуульчийн зүгээс олон удаагийн тв ярилцлагад оролцож байв. - Сүүлийн 2 жилийн хугацаанд байгаль орчин болон түүх археологи, соёлын биет болон биет бус өвийн талаар судалгаа хийж энэхүү сэдвээр доктор хамгаалахаар 2026 оноос Дотоод хэргийн их сургуулийн докторын хөтөлбөрт хамрагдаад байна.
<p>4.2</p>	<p>Байгаа бол хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл</p> <ul style="list-style-type: none"> -Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ. -Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ. -Сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ. -Сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө. Жич: Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх цахим холбоосыг тусгана. <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
<p>4.3</p>	<p>Байгаа бол Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл (гэрчилгээ)</p> <p>Хуульчийн мэргэжлийн, эсхүл өмгөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх зэрэг хууль зүйн мэргэжлийн үйл ажиллагааны зөвшөөрөлтэй юу, эсхүл ийм зөвшөөрөлтэй байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан</p>

	<p>бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг зөвшөөрлийг ямар хугацаанд эзэмшиж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>- 2021оны 01 сарын 28-ны өдөр Монголын өмгөөлөгчдийн холбооны гэрчилгээ,</p> <p>- 2016 оны 10 сарын 28-ны өдөр Улсын Дээд Шүүхээс Өмгөөллийн шүүхэд төлөөлөх эрхийн гэрчилгээ,</p> <p>- 2015 оны 11 сарын 23-ны өдөр Монголын Хуульчдын холбооны “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх” зөвшөөрлийн гэрчилгээ</p>
4.4	<p>Байгаа бол магистр ба түүнээс дээш эрдмийн зэрэг цолны талаарх мэдээлэл</p> <p>Суралцаж төгссөн их, дээд сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн он дарааллаар жагсааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, эрдмийн зэрэг, цол авсан огноог бичнэ.</p> <p>2026-2027 оны Дотоод хэргийн их сургуулийн Докторын хөтөлбөрт хамрагдаж, багц цаг судалж эхэлж байгаа бөгөөд судалгааныхаа сэдвийг Соёлын өвийг хамгаалах тухай хууль, соёлын биет өвийн хууль эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр хамгаалах төлөвлөгөөтэй байна.</p>
4.5	<p>Сахилгын шийтгэл</p> <p>Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж, эсхүл огцорч байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Үгүй</p>

Хавсралт:

Нэр дэвших тухай хүсэлтэд журмын 5.1.1-д заасан дараах баримт бичгийг хавсаргана:

- төрийн албан хаагчийн анкет;
- иргэний үнэмлэхийн хуулбар;
- нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;
- эрх зүйн бакалаврын, эсхүл түүнээс дээш боловсролын зэргийн дипломын хуулбар;
- хууль зүйн өндөр мэргэшилтэй гэдгийг нотлон харуулсан үйл ажиллагааны талаарх баримт;
- эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласныг нотлох баримт;
- энэхүү загварт заасан баримт бичиг;
- холбогдох бусад баримт.

Хүсэлт гаргагч:

Эцэг/эхийн нэр:.....

Өөрийн нэр:

Гарын үсэг:

Он, сар, өдөр:

---oOo---